



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/707

Мөрөн сум

Нэрлэсэн жил зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын бодлогыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, өрхийн эдийн засгийн өсөлтийг хангах, амьдрах орчны таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлж, 2025 оныг “Амьдрах орчноо сайжруулж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарласугай.

2.Нэрлэсэн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг “Амьдрах орчин аятай, өрхийн үйлдвэрлэл өөдөө” уриан дор боловсруулан хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, 2025 оны 12 дугаар сарын 01-ний дотор тайлагнаж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэст тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР